



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/370.

Арвайхээр сум

Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан
өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ
авах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар хурлын "Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох, мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх" тухай тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд чанартай зохион байгуулах" 01 дүгээр албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны "Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай" А/125 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээний зорилтот мал сүргийг бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах ажлыг 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулах ажил эхэлж байгаатай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-нд заасан "Малын тоо толгойн албан татвараас 30 хүртэл хувийг мал аж ахуйн эрүүл мэндийг хамгаалахад зарцуулна" гэсэн заалтыг орон нутагтаа хэрэгжүүлж, ажлын хэсэг томилон, шаардлагатай зардлыг төсөвлөж, зарцуулахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, ажлын явц, үр дүнд хяналт тавьж, дүнг танилцуулж, холбогдох газар хүргүүлэхийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0716

D:My Doc. Zahiramj. Zasag darga